

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн
дэд даргын 2021 оны 11 дугаар тушаалын
дүзэр хавсралт

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

УХА0064

ИЕРОНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан
- Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

Байгууллагын нэр:

Нэгжийн нэр:

Засгийн газрын Хэрэг эрхлэх газар

Орон нутгийн удирдлага,
зохицуулалтын газар

Албан тушаалын нэр:

Албан тушаалын ангилал, зэрэглэл

Орон нутгийн хөгжлийн бодлогын асуудал
хариуцсан Засгийн газрын ахлах референт

Эрхэлсэн түшмэл, АА-4

Ажлын цаг

Ажлын байрны албан ёсны байршил:

Ажлын өдрийн 8 цаг

Улаанбаатар-12, Төрийн ордон

Хөдөлмөрийн нөхцөл:

Онцгой нөхцөл:

Хэвийн

Хамаарахгүй

АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Орон нутгийн хөгжлийн нэгдсэн бодлого, бусчилсэн хөгжлийн асуудалтай холбогдсон
бодлогын удирдамж, төлөвлөлт, шийдвэрийн үндэслэлийг сайжруулахад чиглэсэн
зөвлөгөө, бодлогын хувилбарыг санал болгох, мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж,
гүйцэтгэлийн үр дүнг газрын даргын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

- 1.Орон нутгийн хөгжлийн нэгдсэн бодлого, бүсчилсэн хөгжлийн бодлого боловсруулах, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдсон эрх зүйн орчинг боловсронгуй болгох, стратеги, төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйн зөвлөгөө, дэмжлэгээр хангах;
- 2.Хариуцсан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Тэргүүлэгчид, Засаг даргаас бүрэн эрхээ хэрэгжүүлж буй байдалд хяналт тавих, тэдгээрийн үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангахад удирдлагыг мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэгээр хангах
- 3.Байгууллага, иргэдээс ирүүлсэн санал, хүсэлт, өргөдөл, гомдолд хариу өгөх ажил үйлчилгээг хариуцан гүйцэтгэх;
- 4.Хууль тогтоомжид заасан нийтлэг үүргийг хэрэгжүүлэх.


Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах-Т, Хариуцан гүйцэтгэх-Г Хянах-Х Шийдвэрлэх-Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	<p>1.Монгол Улсын төрийн бодлогод нийцсэн орон нутгийн хөгжлийн нэгдсэн бодлого болон бүсчилсэн хөгжлийн бодлого боловсруулах, зохицуулах, боловсронгуй болгох, дэмжихтэй холбогдсон хууль, Засгийн газрын шийдвэрийн төсөл боловсруулж, шийдвэрлүүлэх;</p> <p>2.Орон нутгийн хөгжлийн нэгдсэн бодлого, бүсчилсэн хөгжлийн бодлого боловсруулах, түүнийг хэрэгжүүлэх, үйл ажиллагааны эрх зүйн орчинг боловсронгуй болгохтой холбогдсон бодлогын удирдамж, төлөвлөлт, зөвлөгөөгөөр Ерөнхий сайд, Танхим, ЗГХЭГ-ын удирдлагыг хангах, бүх шатны Хурал, Тэргүүлэгчдийг мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэгээр хангах;</p> <p>3.Орон нутгийн хөгжлийн асуудлаар гарсан шийдвэр, эрх зүйн орчныг судалж, санал, дүгнэлт гаргаж, бодлогын хувилбаруудаар удирдлагыг хангах;</p> <p>4.Хөдөөгийн хөгжлийн асуудлаар орон нутагт тулгамдсан асуудлыг судалж, санал, шийдвэрийн төсөл боловсруулах, шийдвэрлүүлэх арга хэмжээ авах;</p>	<p>Бодлого боловсруулах, зохицуулах, төлөвлөлтийг боловсронгуй болгох ажлын уялдаа холбоо хангагдсан, шийдвэрийн төсөл нь холбогдох хуульд нийцсэн байна.</p>	G, Ш
		Хууль, эрх зүйн хүрээнд санал, дүгнэлт гаргаж удирдлагыг зөвлөгөө, мэдээллээр хангана.	Г,Ш
		Үнэн зөв мэдээлэлд үндэслэсэн, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх санал боловсруулсан байна.	

	<p>5.Орон нутгийн хөгжлийн асуудлаар үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллаж, тэдний санал, дүгнэлтийг авч санал, дүгнэлт боловсруулах;</p>	Хамтын ажиллагаа өргөжсөн, оролцоо хангагдсан байна.	Г
	<p>6.Орон нутгийн хөгжлийн асуудлаар санал дэвшүүлэх, хэлэлцүүлэг явуулах, үр дүнг нэгтгэх, шийдвэрийн төсөл боловсруулах;</p>	Үр дүнг нэгтгэн хуульд нийцүүлэн шийдвэрийн төсөл боловсруулсан байна.	Г
	<p>7.Хөгжлийн зарим үзүүлэлтээр аймгуудын харьцуулсан судалгаа хийж, мэдээллийн нэгдсэн сан бий болгох;</p>	Үнэн зөв мэдээллийн сан бүрдүүлсэн байна.	Г, Х
	<p>8.Орон нутгийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн санал боловсруулж шийдвэрлүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулах;</p>	Санал нь хуульд заасан шаардлага хангаж, шийдвэрлүүлсэн байна.	Г, Х
	<p>9.Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын хуульд заасан бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, бүсчилсэн хөгжлийн асуудлаар Засгийн газрын ерөнхий стратегийг тодорхойлох чиг үүрэг бүхий орон тооны бус Үндэсний хорооны ажлыг хариуцах;</p>	Бүсчилсэн хөгжлийн асуудлаар хуульд заасан зохицуулалтыг хэрэгжүүлсэн байна.	Г
	<p>10.Бүсчилсэн хөгжлийн бодлоготой уялдуулан аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт болон сумын хөгжлийн дунд хугацааны бодлого боловсруулахад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх;</p>	Хуульд нийцсэн, цаг үеэ олсон зөвлөгөө, дэмжлэг үзүүлсэн байна.	Г, Т
	<p>11.Бүс нутгийн хөгжлийг дэмжих үйл ажиллагаанд гадаадын хөрөнгө оруулагчид, олон улсын байгууллагын оролцоог өргөжуулэх арга хэмжээ авах;</p>	Хөрөнгө оруулагчдын оролцоо нэмэгдэх нэхцэл бүрдсэн байна.	Г
	<p>12.Бүс нутгийн хөгжлийн тодорхой асуудлаар судалгаа шинжилгээний төсөл захиалах, тендерт шалгарсан төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах.</p>	Хууль тогтоомжийн хүрээнд ажлыг зохион байгуулсан байна.	Г, Х
2 дугаар зорилтын хүрээнд	<p>1.Хариуцсан аймгийн Засаг дарга нарын бүрэн эрхээ хэрэгжүүлж байгаа байдалд хяналт тавих, тэдгээрийн үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах, удирдлагад</p>	Хууль тогтоомжид нийцсэн мэргэжлийн зөвлөгөө, дэмжлэг үзүүлж, хяналт тавьж ажилласан байна.	

	зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх; 2. Ерөнхий сайд, ЗГХЭГ-ын удирдлага орон нутагт ажиллах бэлтгэлийг хангах, зохих үйлчилгээг үзүүлэх /маршрут, бүрэлдэхүүн, хэлэх уг, бусад бичиг баримтыг боловсруулах/;	Шуурхай, цаг хугацаанд нь ур дунтэй бэлтгэл ажлыг хангасан байна.	Г
	3. Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүдийн орон нутагт ажилласны мөрөөр авах арга хэмжээ, шийдвэрийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанд оруулан шийдвэрлүүлэх;	Засгийн газрын хуралдаанаас гарч байгаа шийдвэр нь хууль тогтоомжид нийцсэн байна	Г, Х
	4. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны чиглэл, салбарын зарим асуудлаар хариуцсан аймгийн Засаг дарга нарын сонсгол, мэдээллийг бэлтгүүлж, Засгийн газрын хуралдаанд оруулах, гарах шийдвэрийн төсөл боловсруулах;	Хуулийн хүрээнд зохион байгуулалтын арга хэмжээ авсан байна.	Г
	5. Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдаас аймгийн удирдлагад өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг тооцож танилцуулах;	Биелэлтийг тооцож, удирдлагад танилцуулж, үнэн зөв мэдээллээр хангасан байна.	Г, Х
	6. Хариуцсан аймгийн нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллага, иргэдээс Ерөнхий сайд, Засгийн газарт хандаж тавьсан асуудал, өргөдөл, гомдол, санал хүсэлтийг холбогдох журмын дагуу судалж, шийдвэрлүүлэх, Засгийн газраас цаашид хэрэгжүүлэх бодлого, чиглэлд тусгуулах арга хэмжээ авах;	Саналаа боловсруулж Засгийн газраас хэрэгжүүлэх бодлогод тусгасан байна.	Г, Х
	7. Төрийн захиргааны төв байгууллага, аймгийн ИТХ, Тэргүүлэгчид, Засаг дарга нарын хоорондын ажиллагааг зохицуулах, орон нутгаас тавьсан асуудлыг шийдвэрлүүлэх чиглэлээр яам, агентлагтай ажиллах, орон нутгийн ажилтнуудад дэмжлэг зөвлөгөө үзүүлэх;	Холбогдох арга хэмжээг авсан байна.	Г, Т
	8. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд аймаг, орон нутгаас шууд хариуцаж хэрэгжүүлэхээр тусгагдсан	Хэрэгжүүлэхээр тусгагдсан ажлын хяналт тавьж, хуулийн үндэслэлтэй зөвлөгөө,	ЗАВДАВЧИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ


	асуудлын явц байдалд хяналт тавьж, дэмжлэг зөвлөгөө үзүүлэх;	дэмжлэг үзүүлсэн байна.	
	9.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны чиглэл, салбарын зарим асуудлаар хариуцсан аймгийн Засаг дарга нарын сонсгал, мэдээллийг бэлтгүүлж Засгийн газрын хуралдаанд оруулах, гарах шийдвэрийн төсөл боловсруулах;	Засгийн газрын хуралдаанаас гарч байгаа шийдвэр нь хууль зүйн үндэслэлтэй, боловсруулалтын шаардлага хангасан байна.	Г, Х
	10.хариуцсан аймгуудын Засаг дарга нарын Ерөнхий сайдтай байгуулсан батламжийн хэрэгжилтийн байдалд хяналт тавьж зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх;	Батламжийн хэрэгжилтэд хяналт тавьж, тухай бүрт танилцуулсан байна.	Г
	11.хариуцсан аймгуудын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийн үндсэн чиглэлийн хэрэгжилтэд хяналт тавьж, зөвлөгөө өгөх;	Хэрэгжилтэд хяналт тавьж, шуурхай зөвлөгөө, дэмжлэг үзүүлсэн байна.	Г; Х
	12.хариуцсан аймгийн ИТХ, Тэргүүлэгчид, Засаг дарга, Тамгын газрын үйл ажиллагаатай газар дээр нь танилцах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө дэмжлэг үзүүлэх, эдийн засаг, нийгмийн хөгжлийн болон бусад асуудлаар судалгаа шинжилгээ хийх, доголдож буй асуудлыг шийдвэрлэх талаар үүрэг чиглэл өгөх, биелэлтийг дүгнэх;	Тухай бүрт шинжилгээний үр дүнд тулгуурласан санал боловсруулж шийдвэрлэх талаар холбогдох арга хэмжээ авсан байна.	Г, Х
	13.байгуулагдсаны тэгш ой тэмдэглэх хариуцсан аймаг, суманд Ерөнхий сайдаас явуулах илгээлт, мэндчилгээ боловсруулах, хэвлүүлж, хүргүүлэх;	Цаг хугацаанд нь төлөвлөн хийж гүйцэтгэсэн байна.	Г, Х
	14. ЗГХЭГ-ын удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь чанартай гүйцэтгэж, эргэн тайлагнах;	Ажлын гүйцэтгэлийг шуурхай, чанартай хийж гүйцэтгэсэн байна.	Г
	15.хариуцсан аймгуудад Засгийн газар, удирдлагаас өгсөн үүрэг, даалгаврын биелэлт, түүний явц, үр дүн, өмнө нь Ерөнхий сайд тухайн аймагт очихдоо өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт, аймгуудаас тавьсан тулгамдаж буй асуудал зэрэг судалгааг гарган тогтмол баяжилт хийж, удирдлагыг	Үүрэг даалгаврын хэрэгжилт, тулгамдсан асуудлын судалгааг тогтмол гаргаж удирдлагыг үнэн зөв мэдээллээр хангасан байна.	

	нэгдсэн мэдээллээр хангаж байх;		
	16. улсын тэргүүний /загвар/ сум шалгаруулах болзлын биелэлтийг дүгнэх ажиллагаанд оролцох.	Холбогдох журмын дагуу шалгаруулсан байна.	Г, Т
3 дугаар зорилтын хүрээнд	1. Засгийн газар, Ерөнхий сайд, ЗГХЭГ-т төрийн захиргааны бүх шатны байгууллага, аж ахуйн нэгж, иргэний нийгмийн байгууллага, иргэдээс ирүүлсэн санал, хүсэлтийг судлах, хариу төлөвлөх, эрх бүхий албан тушаалтанд шилжүүлэх эсэх талаар удирдлагад танилцуулах, зохих журмын дагуу шийдвэрлэх.	Санал, хүсэлт, өргөдөл, гомдолд өгсөн хариу нь хууль тогтоомжид нийцсэн байна.	Х, Г
	1. ЗГХЭГ-ын удирдлага, нэгжийн даргаас өгсөн хуульд нийцсэн үүрэг даалгаврыг биелүүлэх, Ерөнхий сайдын захирамж, ЗГХЭГ-ын даргын тушаалаар байгуулсан холбогдох Ажлын хэсэгт орж ажиллах;	Холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна	Г
4 дүгээр зорилтын хүрээнд	2. Засгийн газар, Ерөнхий сайд, ЗГХЭГ-т төрийн захиргааны бүх шатны байгууллага, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага, иргэдээс ирсэн санал хүсэлтийг хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэхтэй холбоотой зөвлөгөө, үйлчилгээгээр удирдлагыг хангах, асуудлыг судалж хариу төлөвлөх, холбогдох байгууллага, албан тушаалтанд шилжүүлэх асуудлыг судалж удирдлагад танилцуулж зохих журмын дагуу шийдвэрлэх;	Холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна	Г
	3. эрхэлсэн ажил үүргийн хүрээнд шийдвэрлэсэн асуудлын хяналтын картыг тухай бүрт нь хаах, үйл ажиллагааны явцад гарсан баримт бичгийг ангилан хэрэг бурдуулж, Засгийн газрын архивт зохих журмын дагуу шилжүүлсэн байх.	Холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна	Г
	4. тухайн албан тушаалын чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан холбогдох нууцын баталгааг авахад шаардагдах материалыг гаргаж өгөх.	Холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна	Хууль нийцсэн ТӨРИЙН АЛБАНЫ ӨФИЦИАЛЫГ ШИЛЖҮҮЛСЭН



III АЛБАН ТУШААЛДАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Магистр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх.		
Мэргэжил	<ul style="list-style-type: none"> -нийгмийн шинжлэх ухаан (031); -удирдахуйн ухаан (0413); -эрх зүй (042); -хүмүүнлэг (0223); -эдийн засаг (0311). 		
Мэргэшил	Эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж төгссөн байх.		
Туршлага	Төрийн албанад 12-оос доошгүй жил, үүнээс ахлах түшмэлийн албан тушаалд 4-өөс доошгүй жил ажилласан байх.		
Ур чадвар	Удирдан зохион байгуулах	<ul style="list-style-type: none"> - эрсдэлийн удирдлагад суурилсан хяналтыг хэрэгжүүлэх ажлын гүйцэтгэл, үр дүнг хариуцаж, үүрэг, хариуцлага хүлээх; - байгууллагын алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйлс, стратегийг хэрэгжүүлэх; - ажлаа төлөвлөх, зохион байгуулах, тайлагнах; - хууль зүйн бичлэгийн техник болон практик ур чадвар эзэмшсэн байх; - саналын зөрүү, үл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах; - бусад. 	
	Дүн шинжилгээ хийх	<ul style="list-style-type: none"> - төсөлд эрх зүйн дүгнэлт хийх; - төслийн заалтын шууд ба шууд бус үр дагаврыг тооцож шийдлийн хувилбар боловсруулах; - мэдээлэлд тулгуурлан харьцуулсан шинжилгээ хийх; - бодлогын үндэслэлтэй дүгнэлт, зөвлөмж, тайлбар бэлтгэх; - бусад. 	
	Асуудал шийдвэрлэх	<ul style="list-style-type: none"> - Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулийг чандлан баримталж, үндэсний язгуур ашиг сонирхолд захирагдан ард түмэндээ үйлчилж, төрд чин үнэнчээр зүтгэх; - аливаа асуудлыг албан тушаалын бүрэн эрхийн хүрээнд хууль болон ёс зүйн зарчимд нийцүүлэн ашиг сонирхлоос ангид шийдвэрлэх; - хуульд нийцсэн, бодит баримт нотолгоонд тулгуурласан, үндэслэл бүхий үнэн зөв мэдээлэл, мэргэжлийн зөвлөгөөгөөр хангах; - хийсэн ажлынхаа гүйцэтгэл, үр дүнгийн төлөө бүрэн хариуцлага хүлээх; - бусад. 	
	Манлайлах	<ul style="list-style-type: none"> - төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиж, ёс зүйгээр бусдыг манлайлах; - ажил хэргийн хувьд бүтээлч, санаачилгатай ажиллах; - хувийн зохион байгуулалт, цаг ашиглалтын хувьд бусдыг манлайлах; - байгууллагын болон нэгжийн үйл ажиллагааны шинэttгэлийн үзэл санааг бусдад итгүүлэн ойлгуулах, хэрэгжүүлэх; - бусад. 	
	Бусад	<ul style="list-style-type: none"> - албан хэрэг хөтлөх, баримт бичиг боловсруулах; - хууль зүйн техникийн болон практик ур чадвар Эзэмшилсэн байх; - англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийн эх сурвалжийг сашиглах чадвартай байх; - компьютерын хэрэглээний программыг, мэдээлэл харилцааны технологийг ашиглах чадвартай байх; 	



		<ul style="list-style-type: none"> - багаар ажиллах, мэдээллээ хуваалцах; - иргэн, албан тушаалтан, гишүүдтэй зелдэг, соёлтой, хүндэтгэлтэй харилцах; - худалдан авах ажиллагааны сургалтад хамрагдаж АЗ гэрчилгээ авсан байх; - төрийн нууцтай танилцах эрх олгохтой холбоотойгоор аюулгүй байдлын шалгалт явуулахыг бичгээр зөвшөөрч, эрх бүхий байгууллагын аюулгүй байдлын шалгалтад хамрагдаж, тэнцсэн байх; - кирилл болон үндэсний бичгээр албан хэрэг боловсруулах чадвартай байх.
--	--	---

АЛБАН ТУШААЛЫН ХАРИЛЦАХ СУБЬЕКТ

Албан тушаалыг шууд харьялан удирдах албан тушаалын нэр:

- Орон нутгийн удирдлага, зохицуулалтын газрын дарга.

Албан тушаалд шууд харьялан удирдуулах албан тушаалын нэр, тоо:

Бусад харилцах субъект

- 1.Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Тэргүүлэгчид, удирдлага, Ажлын алба;
- 2.Аймаг, нийслэлийн Засаг дарга, Тамгын газар;
- 3.Яам, агентлаг, төрийн бусад байгууллагын холбогдох албан тушаалтан;
- 4.Улсын Их Хурлын болон Ерөнхийлөгчийн Тамгын газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Үндсэн хуулийн цэц, Төрийн албаны зөвлөл, тэдгээрийн Ажлын албаны холбогдох албан тушаалтан;
- 5.Иргэн, хуулийн этгээд

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:

Албан тушаал: ДЭД ДАРГА

.....
У.БЯМБАСҮРЭН

2021 оны ... дугаар сарын ... -ныөдөр

Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:

Байгууллагын нэр:
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

Шийдвэрийн огноо:

Дугаар: 21 0911
219

Албан тушаалын тодорхойлолт баталсан:

Байгууллагын нэр:
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

Шийдвэрийн огноо: Тэргүүн дэд даргын 2021 оны 09 дугаар сарын 21-ны өдрийн тушаал


Дугаар: 211

(тамга/тэмдэг)

ТЭРГҮҮН ДЭД ДАРГА

(Гарын үсэг)

2021 оны 09 дугаар сарын 21-ны өдөр



(Эцэг/эх-/ийн нэр, барийн нэр)

Б.ГАНБАТ

УПС

МОНГ

ЗӨВШӨӨРӨӨ

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

МОНГ

ЗӨВШӨӨРӨӨ

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ